

3

ОРЧИН ҮЕИЙН СТАТИСТИКИЙН МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Б.Ганбат

Өнөөгийн байдал

Үндэсний статистикийн салбарт 255 албан хаагч ажил үүрэг гүйцэтгэж байгаагаас орон нутагт 149 албан хаагч ажиллаж байна. Үндэсний статистикийн хорооны албан хаагчдын 3,1 хувь нь доктор, 12,9 хувь нь магистр, 80,2 хувь нь бакалаврын боловсролтой байгаа бөгөөд 51,4 хувийг статистикч-эдийн засагч, 3,5 хувийг хүн ам зүйч статистикч нийтдээ 55 хувь нь статистикчид байна.

Статистикийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэхдээ статистикийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг үндсэн сургууль болох МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг статистикийн мэргэжлээр төгсөж буй шинэ залуу боловсон хүчнээр бэхжүүлэх үндсэн чиглэл зорилго баримталж байна.

Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн дагуу Статистикийн аль I шатны байгууллага нь төрийн захиргааны байгууллагын хувьд ажлын сул байрыг нийтэд зарлан төрийн албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс мэргэжил, боловсролын түвшинг харгалзан Төрийн албаны зөвлөлөөс баталгаажуулсан саналын дагуу тухайн зарласан ажлын байранд үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж байна.

Өнөөгийн нөхцөлд манай төгсөгчдөөс Төрийн захиргааны жинхэнэ албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага төрийн захиргааны албан хаагчийн зайлшгүй мэдэж байх хууль, дүрэм, журмын мэдлэг дутмаг байгаагаас төрийн албаны мэргэшлийн шалгалтад амжилтгүй дүн үзүүлж байгаад онцлон анхаарч өөрийн эзэмшиж буй мэргэжилтэй холбоотой болон Эрх зүйт төрийн албан хаагч болно гэдгээ ухамсарлан Төрийн албаны тухай, ТБУСТ, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай зэрэг бусад хууль эрх зүйн мэдлэг, мэдээ мэдээллийг гүнзгийрүүлэн судлаж бие даан суралцах хэрэгцээ, шаардлага зүй ёсоор гарч байна.

Статистикийн байгууллагын ажилтнуудын гол шалгуурт статистикийн шинжлэх ухааны онол, арга зүйн өндөр мэдлэг дадлагыг эзэмшихээс гадна гадаад хэлний мэдлэгийн түвшин ихээхэн үүрэгтэй болж байна. Энэ нь статистикийн шинжлэх ухааны олон улсын аргачлал, арга зүйг судлан, өөрийн үүрэгт ажилд нэвтрүүлэх шаардлага урган гарч буйтай холбоотой юм.

Түүнчлэн Үндэсний статистикийн хорооны гадаад хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж өргөжин тэлж буй ажил үүрэгтэй шууд холбоотой.

Өнөөдөр Үндэсний статистикийн салбарын хоёр талт болон олон талт хамтын ажиллагаатай байгууллагууд болон хөгжингүй орнуудын статистикийн байгууллагуудтай хийгдсэн санамж бичиг, хамтран ажиллах гэрээний дагуу Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага бүрдээд байна. Энэ хүрээнд гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, Монголын Үндэсний статистикийн нэр хүнд дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх зорилтыг хангах зорилгоор гадаадын өндөр хөгжсөн орнуудад урт болон богино хугацааны сургалт, семинарт салбарын ажилтнуудыг байнга өргөн оролцуулдаг боллоо.

Хамтын ажиллагааны хүрээнд Австралийн Статистикийн товчоо, БНЭУ-ын Статистикийн хөтөлбөр, хэрэгжилтийн яамтай хамтарсан Харилцан ойлголцлын санамж бичиг, БНХАУ болон ОХУ-тай хамтын ажиллагааны гэрээ, НҮБ-ын ЕЭЗНК болон ЕЧХ-ны гурвалсан санамж бичиг, СИНФОНИКА байгууллагатай микро тоо мэдээлэл солилцох тунхаг зэргийг байгуулан тодорхой судалгаа, арга зүй, аргачлалын асуудлаар хамтран ажиллаж байна.

Зөвхөн өнгөрсөн 2010 онд нийт 64 гадаад арга хэмжээ, сургалт, семинарын урилга авч, давхардсан тоогоор 117 ажилтан оролцлоо. НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудаас зохион байгуулсан 23 арга хэмжээнд Үндэсний статистикийн хорооны 31 ажилтан оролцлоо.

Мөн түүнчлэн НҮБ-ын Статистикийн комиссын чуулганы жил бүрийн хуралдаанд амжилттай оролцож, АНДНЭЗКомиссын Статистикийн хэлтсийн товчооны даргаар тус хорооны Тэргүүн дэд дарга, Эдийн засгийн үзүүлэлт тодорхойлох чиглэлээр ажиллах техникийн бүлгийн гишүүнээр МЭЗСГ-ын дарга, НҮБ-ын статистикийн хорооноос байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлийн статистикийг сайжруулах Вашингтоны бүлгийн удирдах зөвлөлийн гишүүнээр МБТГ-ын дарга нар тус тус тодорхой үүрэг гүйцэтгэн хавсран ажиллаж байна.

Эрдэм шинжилгээний цар хүрээ, үр өгөөжийг бид илүү түлхүү анхаарч ажиллаж байна

Их дээд сургуульд сурсан эзэмшсэн мэргэжил дадлага, ур чадвараа дээшлүүлж орчин үеийн олон улсын арга, арга зүй, аргачлалд түвшин дээшлүүлж суралцах, хамтарсан судалгаа төсөлд хамтран ажиллах шаардлага улам нэмэгдэж буйтай холбоотой юм

Энэ нь өндөр хөгжилтэй болон хөгжингүй орнуудын магистрантур, докторантурт 2, Ази, номхон далайн орнуудын статистикийн институтээс зохион байгуулж буй дээд түвшний сургалтад 2, Энэтхэгийн Олон улсын

статистикийн институтийн мэргэжил дээшлүүлэх урт хугацааны сургалтад 6 ажилтан тус тус суралцаж байгаагаас тодорхой харагдаж байна.

Олон улсын байгууллагуудын оролцоотойгоор дэлхийн статистикийн систем байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж, боловсронгуй болсоор байна. Олон улсын зөвлөхүүд, экспертүүд Дэлхийн статистикийн системд хэд хэдэн сул талууд байгаагийн нэг нь “Статистикийн чадавхийг бэхжүүлэх асуудал” тулгамдсан хэвээр байна гэдгийг байнга ярьж байна. Чадавхийг бэхжүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх гол арга зам нь ажилтнуудын хэрэгцээ шаардлагыг хангахуйц **сургалт** байх юм. Зөв оновчтой, шинэлэг хэлбэрийн, цаг үеэ олсон **Сургалт нь** аливаа нэг байгууллагын ажилтнуудын чадвар өнөөгийн тавигдаж буй шаардлагын хэмжээнд хүрч дээшлэх гол түлхэх хүч болно.

НҮБСК-оос Сургалт нь нэг талаас ажилтнуудын чадварыг нэмэгдүүлж, шаардлагын хэмжээнд хүргэх, нөгөө талаас харьцангуй чадвар сул ажилтнуудыг ажиллуулахын тулд сургалт хийхэд бус харин **орчин үеийн шаардлагад нийцэхгүй байгаа ажилтнуудаа аль болох богино хугацаанд дадлагажуулан, сургах** зорилтыг тавих ёстой гэсэн зарчмыг зөвлөж байгаа юм.

Учирч буй бэрхшээл, цаашид анхаарах асуудал

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжихийн өмнө МУИС-ийн Эдийн засгийн факультет, Москва хотын Эдийн засаг статистикийн дээд сургуулиар статистикийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж, бэлтгэгдсэн боловсон хүчнүүдээ аймаг, орон нутагт нь нарийн төлөвлөгөөтэйгээр хуваарилан ажиллуулдаг байлаа.

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр статистикийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулийн тоо ихээхэн нэмэгдэж, одоогийн байдлаар МУИС-ийн ЭЗС, МУБИС, ХААИС болон нэлээд хэдэн хувийн дээд сургуулиудад статистикийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж эдгээр сургуулийн оюутнууд Манай Үндэсний статистикийн хороо болон аймаг орон нутагт, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүдэд онолын мэдлэгээ практик амьдралд нийцрүүлэх дадлагын ажлуудыг хийж байна.

Оюутны дадлагын хугацаанд газар, нэгжүүдийн дарга, статистикч, ахлах

шинжээч дадлагын удирдагчаар ажиллан, дадлагын хугацаанд оюутнуудад

байгууллагын бүтэц, зохион байгуулалт, анхан шатны нэгж, аж ахуйн нэгж,

байгууллагаас мэдээ, тайлан хүлээж авах, шалгах, боловсруулах үйл ажиллагаа, мэргэжлийн холбогдолтой аргачлал, арга зүй, тархаалтын үйл ажиллагаатай танилцуулж төгсөгчдийн мэдлэг чадварыг, тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байна.

Дадлагын хугацаанд оюутнуудын ажилд хандах хандлага харилцан адилгүй ялангуяа зарим оюутнуудын онол, арга зүйн мэдлэг сул байгааг дадлага удирдагчид онцлож байна. Тухайлбал мэргэжлийн холбогдолтой ном, сэтгүүлээс материал орчуулахад хэлний түвшин хангалтгүй, монгол хэлний

найруулга, хэл зүйн шаардлага доогуур, баримт бичгийн боловсруулалт хийх чадвар сул төгсөгчид төгсөн гарч буйд анхаарах хэрэгтэй байна.

Сургууль төгссөн мэргэжилтнүүд ажлын байрандаа шууд ажиллах болдог тул тухайн ажлын байрны шаардлага хангахгүй байна. Иймээс бид дараах асуудлуудад анхаарлаа төвлөрүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа юм. Үүнд:

- л Сургалтын төлөвлөгөөний бүтцэд зарим өөрчлөлт оруулан, онол практик хоёрын нягт уялдааг хангах, мэргэжилтнүүд төгсөөд шууд ажиллах чадвартай болсон байх
- л Оюутнуудыг эрдэм шинжилгээний ажилд өргөн татан оролцуулж эрдэм

шинжилгээний ажлын цар хүрээг нэмэгдүүлэн, зарим төрлийн судалгааны ажлыг Үндэсний статистикийн хороотой гэрээ байгуулан хамтран ажиллах.

1. Статистикийн судалгаа, шинжилгээний хэрэглээний багц програмуудыг ашиглах чадварыг улам нэмэгдүүлэх, шинээр гарч буй аргачлалуудыг сургалтад өргөн ашиглах
2. Англи хэл болон бусад сонгодог хэлний мэдлэг, тэдгээрийн статистикийн шинжлэх ухааны мэргэжлийн үг хэллэгийг маш сайн эзэмших, эзэмшүүлэх
3. Монгол хэлний хэл зүйн дүрмийн болон найруулгын мэдлэгийг сайжруулж, бичих зүйлийн гол агуулгыг товч бөгөөд тодорхой гаргах чадварыг нэмэгдүүлэх
4. Төгсөгчдийг төгссөн сургуультайгаа эргэх холбоотой ажилладаг механизм, хөшүүрэг бий болгох
5. Төрийн байгууллагад ажиллах ёс зүйн хүмүүжил эзэмшүүлэх.
6. Сургууль төгсөгчдөд хууль эрх зүйн холбогдолтой нэмэлт хичээлийг сургалтын хөтөлбөрт оруулж байх

Дээрх зайлшгүй шаардлагыг хэрэгжүүлж чадвал статистикийн мэргэжлээр төгсөж байгаа их, дээд сургуулиудын боловсон хүчний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хөгжлийн шинэ үетэй хөл нийлүүлэн ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэгдэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.